



**2021 оны Намрын улиралд суралцагчдыг Хамрах хүрээний Үйл явц: Баталсан тухай Мэдэгдэл
Захидал: 46140, 48150, 48280, 48281, 48290 төлөвлөлтийн нэгжид оршин суудаг 5-р ангид
суралцагчдын гэр бүлийнхэн**

2021 оны 12 сарын 10

Хүндэт 5 дугаар ангид суралцагчдын гэр бүлийнхэн Танаа:

2021 оны 12-р сарын 2-ны өдөр Сургуулийн Удирдах Зөвлөл 2022 оны 8-р сараас хэрэгжүүлж эхлэх 2021 оны Намрын улиралд суралцагчдыг Хамрах хүрээний Өөрчлөлтийг батлан санал хураалаа.

46140, 48150, 48280, 48281, 48290 төлөвлөлтийн нэгжүүдийн 2022-23 оны хичээлийн жилд суралцагчдыг Ганстон сургуулиас Жефферсон Дунд Сургууль руу шилжүүлэн суралцуулахаар болсон. Энэхүү өөрчлөлт нь дээр дурдсан төлөвлөлтийн нэгжид амьдардаг 6-р ангид орох бүх сурагчид (2021-2022 онд 5-р ангид суралцагчид) болон дунд сургуульд элсэн орох сурагчдад хамаарна. Хоёр Хэлний Хосолсон Сургалт эсвэл Монтессори хөтөлбөрт хамрагддаг сурагчид Ганстон Дунд Сургуульд тухайн хөтөлбөрүүдээрээ үргэлжлүүлэн суралцах боломжтой. Тодруулбал, 2021 оны 6-р сарын 17-ноос өмнө дээрх төлөвлөлтийн нэгжүүдийн аль нэгэнд амьдардаг 6-7 дугаар ангийн сурагчид болон Ганстон сургуульд суралцаж байгаа эсвэл Ганстон сургуульд элсэн орсон сурагчид Ганстон сургуульд 8-р ангиа дүүргэх эсвэл 2022-23 оны хичээлийн жилээс эхлэн шинээр төлөвлөгдсөн зэргэлдээх сургууль (Жефферсон Дунд Сургууль)-д суралцах боломжтой.

Ах, эгч дүүс болон Тээвэрлэлтийн талаарх Мэдээлэл

- **Ах, эгч дүүс :** Дээрх төлөвлөлтийн нэгжүүдийн аль нэгэнд оршин суудаг Ганстон сургуулийн 6-7 дугаар ангийн сурагчдын 5-р ангид суралцдаг дүү нар нь Ганстон сургууль руу шилжих боломжтой тул 2022-23 оны хичээлийн жилд ах, эгчийнхээ хамт Ганстон Дунд Сургуульд элсэн орж суралцах боломжтой. Эдгээр сурагчдын гэр бүл бүрт захидал, маягтуудыг тус тусад нь илгээнэ.
- **Тээвэрлэлт :** АУС нь Жефферсоны Дунд Сургууль (шинээр төлөвлөгдсөн зэргэлдээх сургууль)-д элсэн орсон зорчих бүсээс гадна оршдог дээрх төлөвлөлтийн нэгжүүдэд амьдардаг сурагчдад тээврийн хэрэгслээр үйлчилнэ. Дунд сургуулийн нэмэлт сургууль/хөтөлбөрт хамрагдаж байгаа суралцагчдад мужийн төвлөрсөн зогсоолоос АУС-ийн тээврийн хэрэгслээр үйлчлэх болно.

Хэрэв та бүхэнд тодруулах зүйл байвал engage@apsva.us хаяг руу цахим шуудан илгээх эсвэл Төлөвлөлт, Үнэлгээний албатай 703-228-2481 утсаар холбогдон авна уу. 2021 оны Намрын улирлын Хамрах хүрээний Үйл явцын талаарх нэмэлт мэдээллийг <https://www.apsva.us/engage/fall-2021-boundary-process> холбоосоор орж авна уу.

Баярлалаа,

Лиза Стенгл
Төлөвлөлт, Үнэлгээний Албаны Дарга
Арлингтоны Улсын Сургууль